



МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/22


Улаанбаатар хот

Дотоод аудитын төлөвлөгөө
батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2021 оны Дотоод аудитын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Дотоод аудитын төлөвлөгөөний биелэлтийг дараа оны 1 дүгээр улиралд багтаан Төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулж, тайлагнахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Одхүү/-т даалгасугай.



Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2021... оны 02 сарын 16 ны өдрийн 2 дугаар
тушаалын хавсралт



**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
2021 ОНЫ ДОТООД АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Дотоод аудитаар хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах журмын 2018-2020 оны хэрэгжилтэд дотоод аудит хийх	5 дугаар сард	Х.Цэнд-Аюуш Н.Цогтбаяр Д.Батнайрамдал
2	Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тухайн агуулахад гаргасан техник, технологийн дүгнэлт, агуулахын бүртгэлийн гэрчилгээ олгосон байдалд дотоод аудит хийх	10 дугаар сард	Бүгд /АМГТГ-ын Хяналт шинжилгээ, судалгааны хэлтэстэй хамтрах/
3	Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн зөвлөмжийн дагуу яамны архив, албан хэрэг хөтлөлтөд дотоод аудит хийх	4 дүгээр сард	Н.Цогтбаяр Ж.Энхсайхан
4	УУХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтэд аудит хийх.	Хагас, бүтэн жилээр	Х.Цэнд-Аюуш
5	Шаардлагатай тохиолдолд удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус аудитыг хийж гүйцэтгэх	Тухай бүр	Бүгд

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР